

МОНГОЛ, ЯПОНЫ БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАРИЛЦАА: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Х.ХИШИГСҮРЭН

Дэд хурандаа,

Аюулгүй байдал судлалын магистр

Оршил

Монгол Улсад 1990-ээд оны эхээр өрнөсөн ардчилал, хүний эрх, эрх чөлөөний төлөөх тэмцлийн үр дүнд парламентын засаглал бүхий ардчилсан улс болж, социалист лагериас тусгаарлан, ардчиллын үнэт зүйлсийг хөгжүүлж, голчлон социалист системийн улсуудтай хөгжүүлж ирсэн харилцаа, хамтын ажиллагаагаа дэлхийн бусад улсуудтай, тэр дундаа өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай хөгжүүлж ирлээ.

Монгол Улс нь ардчилсан үзэл баримтлалыг үндэс болгосон шинэ үндсэн хуулиа 1992 онд баталж, улмаар 1994 онд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Цэргийн номлол”¹-ыг тус тус баталсан.

Энэхүү “Цэргийн номлол”-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, түүнд сөргөөр нөлөөлж болох гадаад, дотоод хүчин зүйл, учирч болзошгүй аюул заналхийллээс сэргийлэх, үндэсний язгуур ашиг сонирхол, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, улсын хилийн халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах, дайны аюулаас сэрэмжлэн зайлуулах, улс орноо түрэмгийллээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг юм.

“Цэргийн номлол” нь 1998 онд “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс”, 2015 онд “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” нэршилтэйгээр өөрчлөгдөн батлагдсан.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгүүдэд тусгаар тогтнолоо улс төр, дипломатын аргаар бэхжүүлэхийг урьтал болгоно

¹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай (legalinfo.Mn)

хэмээн заасны дагуу бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх, батлан хамгаалах салбарыг бэхжүүлэн хөгжүүлэхэд батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой хэмээн үзэж, АНУ, ХБНГУ, Япон Улс, БНЭУ, БНТУ, БНСУ, Канад Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, БНПУ зэрэг улсуудтай цэргийн харилцаа тогтоож ирсэн.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Ш.Жадамбаа нь 1995 оны 2 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд Япон Улсын ГХЯ-ны урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийж, цэргийн албан ёсны дипломат харилцаа тогтоож, батлан хамгаалахын атташег харилцан /Бээжингээс хавсран/ суулгах асуудал хөндөгдсөн байдаг.

Улмаар, 2000 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Япон Улсын Засгийн газраас Монгол Улстай батлан хамгаалах салбарт албан ёсны харилцаа тогтоохоор шийдвэрлэн, тус улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Батлан хамгаалахын атташег Монгол Улсад хавсран суулгахаар болж, Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлээр Япон Улстай батлан хамгаалах салбарт атташегийн түвшинд харилцаа тогтоохоор шийдвэрлэсэн². Японы талаас 2017 оны 4 дүгээр сараас дэд хурандаа К.Хондаг, Монголын талаас 2019 оны 4 дүгээр сараас дэд хурандаа Л.Энхбатыг батлан хамгаалахын атташегаар тус тус томилон ажиллуулж эхэлсэн.

Зүүн хойд Азийн бүс нутгийн нөлөө бүхий, аж үйлдвэр, техник технологи өндөр хөгжсөн, ардчиллын үнэт зүйлсийг хөхиүлэн дэмждэг, мэргэжлийн зэвсэгт хүчинтэй Япон Улстай батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд хоёр талын харилцааг бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, цэргийн инженер болон агаарын цэргийн чиглэлд харилцан туршлага судлах, цэргийн алба хаагчдын мэргэжлийн боловсрол, сургалт бэлтгэлийн түвшнийг дээшлүүлэх, энхийг сахиулах ажиллагааны сургалт бэлтгэлийн чиглэлээр идэвхжүүлэн хөгжүүлж байна.

Энэхүү илтгэлээр хоёр улсын батлан хамгаалах салбарын хөгжил, өнөөгийн байдлыг тодотгож, цаашдын чиглэлийг хувь судлаачийн байр сууриар илэрхийлэхийг зорьсон болно.

Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг:

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой буюу 2012 оны 1 дүгээр сард Япон Улсын Батлан хамгаалахын

² Монгол Улсын Батлан хамгаалах яам, Улаанбаатар 2011, х.305

сайд Ичикава Ясуо Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, “Монгол Улсын Батлан хамгаалах яам, Япон Улсын Батлан хамгаалах яам хооронд батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг”-т Батлан хамгаалахын сайд Л.Болдын хамт гарын үсэг зурсан³.

Айлчлалын үеэр Японы Батлан хамгаалахын сайд Я.Ичикава Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд нарт бараалхан, Батлан хамгаалахын сайд Л.Болдын хамт хэвлэлийн бага хурал хийн, санамж бичигт гарын үсэг зурж, хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа шинэ түвшинд гарч байгааг илэрхийлсэн.

Энэхүү санамж бичиг нь Монгол, Японы батлан хамгаалах салбарын хэмжээнд байгуулсан анхны баримт бичиг бөгөөд санамж бичгийг байгуулснаараа Монгол-Японы батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа шинэ түвшинд гарч, бүх түвшний харилцан айлчлал, сургалт судалгаа, хамтарсан сургууль хийх, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны болон олон улсын терроризмтой тэмцэх, гамшгаас хамгаалах, Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээг тогтоосон чухал ач холбогдолтой болсон юм.

Үүнээс гадна Монгол Улсын Цэргийн их сургууль /тухайн үеийн нэршлээр/ болон Япон Улсын Үндэсний Батлан хамгаалахын академийн хоорондын “Хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийг 1998 онд, “Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах судлалын хүрээлэн Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээ”-г 2015 онд, “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2015 онд, “Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал болон Япон Улсын Агаарын өөрийгөө хамгаалах хүчин хоорондын Агаарын цэргийн батлан хамгаалах салбар дахь хамтын ажиллагаа болон солилцооны санамж бичиг”-ийг 2022 онд тус тус байгуулж, хэрэгжилтийг хангаж байна.

Харилцан айлчлал:

Монголын талаас: 1995 онд 2 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Ш.Жадамбаа Япон Улсын ГХЯ-ны урилгаар тус улсад улс төрийн айлчлал хийсэн. Айлчлалын явцад Монгол Улсын Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Ш.Жадамбаа Япон Улсын Төрийн сайд, Үндэсний батлан

³ Японы БХ-ын сайд Ерөнхийлөгчид бараалхав | News.MN 2011.01.11

хамгаалахын агентлагийн /одоогийн Японы БХЯ/ дарга ноён Т.Тамазава, мөн агентлагийн Парламентын асуудал эрхэлсэн дэд дарга ноён Ватасэ, Гадаад хэргийн яамны дэд сайд ноён Янагисава, Парламентын гишүүн ноён М.Сузуки болон албаны бусад хүмүүстэй уулзалт хийсэн. Айлчлалын явцад японы тал монголын цэргийн алба хаагчдыг сургах, цэргийн албан ёсны дипломат харилцаа тогтоож батлан хамгаалахын атташег харилцан (хавсран) суулгах асуудлыг судлан үзэж цаашдын харилцааг хөгжүүлэхээр болсон.

1997 оны 8 дугаар сард Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Д.Дорлигжав Японы Кобе хотноо зохиогдсон “Байгалийн гамшигтай тэмцэх” сэдэвт олон улсын хуралд оролцсон. Энэхүү олон улсын хуралд оролцох явцдаа Д.Дорлигжав Япон Улсын Төрийн сайд, Үндэсний батлан хамгаалахын агентлагийн дарга ноён Кюма-тай уулзаж хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон.

1998 оны 10 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд БХИС-ийн захирал хурандаа Д.Мягмар, сургалтын албаны дарга хурандаа Д.Баярхүү нар Японд зохиогдсон АРФ-ын гишүүн орнуудын БХИС-ийн захирлуудын семинарт оролцов. Тэд семинарт оролцох явцдаа Японы Үндэсний батлан хамгаалахын академид зочилж, хоёр улсын цэргийн сургуулиуд хооронд хамтран ажиллах меморандумд гарын үсэг зурсан.

2003 оны 10 дугаар сарын 6-13-ны өдрүүдэд Япон Улсын Гадаад хэргийн яамны урилгаар Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа тэргүүтэй төлөөлөгчид ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Парламентын дээд танхим, Гадаад хэргийн яам болон Үндэсний батлан хамгаалах агентлаг, штабуудын нэгдсэн хорооны удирдлагатай уулзаж, харилцан сонирхсон асуудлаар болон хамтын ажиллагааны талаар саналаа илэн далангүй солилцон зарим тохиролцоонд хүрч хоёр орны батлан хамгаалах салбарын харилцааг хөгжүүлж бэхжүүлэх нааштай алхам хийгдсэн.

Хоёр тал цаашид цэргийн алба хаагчдыг Япон Улсад сургах /ҮБХА, Батлан хамгаалах институт, магистр, докторантурын чиглэлээр бэлтгэх, сургах/, Энхийг сахиулах хүчний сургалтын чиглэлээр хамтран ажиллах, энэ чиглэлээр мэдээлэл солилцох, туршлага судлах, ажлын хэсэг томилон ажиллуулах, Монгол Улсын БХИС-ийн дэргэд япон хэлний кабинет байгуулах, цөмийн дэлбэрэлтийг чичирхийллийн аргаар судлах техник технологийн салбар болон эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр хамтран ажиллах зэрэг салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хэлэлцэн тохирсон.

2007 оны 1 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Ц.Тогоо Япон Улсад албан ёсны айлчлал хийж, штабуудын нэгдсэн хорооны удирдлагатай ажлын уулзалт, Өөрийгөө хамгаалах

хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, генерал Ц.Моритой албан ёсны хэлэлцээр хийж, Өөрийгөө хамгаалах хүчний зарим нэгтгэл ангиудтай танилцсан.

2010 оны 11 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн Япон Улсад хийсэн Төрийн айлчлалын бүрэлдэхүүнд Батлан хамгаалахын сайд Л.Болд багтан айлчилж, Японы Батлан хамгаалахын сайдтай уулзаж, хамтран ажиллах талаар санал солилцсон.

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Д.Баярсайхан тэргүүтэй төлөөлөгчид 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Япон Улсын Токио хотноо зохион байгуулагдсан Монгол-Японы БХЯ хоорондын Анхдугаар зөвлөлдөх уулзалтад оролцож хоёр улсын батлан хамгаалах хамтын ажиллагаа, солилцооны асуудлаар харилцан санал солилцож чадавхыг дээшлүүлэх хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллахаар төлөвлөж буй цэргийн инженер, эмнэлэг, ЭСА-ны чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцож, цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар тохиролцон, одоо ч үргэлжилж байна.

2013 оны 11 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал З.Болдбаатар Япон Улсад албан ёсны айлчлал хийж, цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон.

2014 оны 3 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий санхүүч, хурандаа Ө.Даваадорж тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсын инженерийн цэргийн чиглэлээр туршлага судлах ажлын айлчлал хийсэн.

2014 оны 4 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Япон Улсын Батлан хамгаалахын сайд И.Онодерагийн урилгаар Монгол Улсын УИХ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид албан ёсны айлчлал хийж бүс нутгийн хэмжээнд тулгарч буй аюулгүй байдлын зарим асуудлууд болон хоёр улсын батлан хамгаалах бодлого, салбарын харилцаа, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцсон.

2015 оны 10 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Нэгдсэн штабын дарга, адмирал К.Каваногийн урилгаар Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Даваа тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсад албан ёсны айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Даваа Япон Улсын Батлан хамгаалахын сайд Г.Накатани, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Нэгдсэн штабын дарга, адмирал К.Кавано, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Хуурай замын цэргийн

командлагч К.Ивата нартай албан ёсны яриа хэлэлцээр хийж, хоёр улсын батлан хамгаалах бодлого, салбарын харилцаа, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцсон.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2019 оны 12 сарын 01-04-ний өдрүүдэд Япон Улсын Батлан хамгаалахын сайд К.Таро-той албан ёсны яриа хэлэлцээ хийсэн. Мөн Япон Улсын Гадаад хэргийн сайд Т.Мотэги, Япон Улсын Төлөөлөгчдийн танхимын Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга М.Хаяаши нартай хоёр талын уулзалт хийж хоёр орны харилцааны асуудлаар санал солилцож, Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах Их сургууль, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Эрүүл мэндийн сургууль, Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлэгт зочлон тус байгууллагуудын гүйцэтгэж буй үүрэг, үйл ажиллагаатай танилцан, хамтран ажиллах боломжийн талаар санал солилцсон.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 11 дүгээр сарын 23-28-ны өдрүүдэд Япон Улсад албан айлчлал хийн, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Агаарын цэргийн штабын дарга генерал Ш.Изүцүтэй “Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал болон Япон Улсын Агаарын өөрийгөө хамгаалах хүчин хоорондын Агаарын цэргийн батлан хамгаалах салбар дахь хамтын ажиллагаа болон солилцооны санамж бичиг”-ийг байгуулж, Батлан хамгаалахын парламентын дэд сайд Ж.Кимура, Нэгдсэн штабын дарга, генерал К.Ямазаки нартай хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Японы талаас:

1997 он 10 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Японы Үндэсний батлан хамгаалах агентлагийн орлогч дарга ноён Ё.Хооцуки тэргүүтэй төлөөлөгчид айлчилсан. Төлөөлөгчдийг УАБЗ-ийн нарийн бичгийн дарга Р.Болд, УИХ-ын Байнгын хорооны дарга С.Зориг, Батлан хамгаалахын сайд Д.Дорлигжав, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал Ц.Дашзэвэг, ГХМСТГ-ын дарга, хошууч генерал Б.Эрдэнэбат нар тус тус хүлээн авч уулзсан. Дээрх уулзалт ярианы явцад ижил зиндааны хүнийг Японд айлчлуулах, боловсон хүчин бэлтгэх, телестуди тоноглоход тусламж үзүүлэх, биеийн тамирын дасгалжуулагч багш бэлтгэхэд туслах зэрэг асуудлуудыг зарчмын хувьд тохиролцож, албан ёсны хүсэлтээ Монгол Улсад суугаа Японы ЭСЯ-аар дамжуулан өгөхөөр болсон.

1998 оны 4 дүгээр сард Японы Батлан хамгаалах судалгааны хүрээлэнгийн ерөнхийлөгч К.Омори тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийж тус хүрээлэнд хүн сургах, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар судлаачид, шинжээчид харилцан солилцохоор зарчмын хувьд тохиролцов.

1998 оны 7 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Японы Батлан хамгаалах судалгааны хүрээлэнгийн Оросын асуудал хариуцсан ахлах судлаач Мий Мицүо, Хятадын асуудал хариуцсан ахлах судлаач Н.Ито нар Монгол Улсад ажлын айлчлал хийж ГХМСТГ, ССХ, ЦИС-ийн судлаачидтай уулзалт ярилцлага хийсэн. Японы судлаачдыг ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Р.Болд хүлээн авч уулзсан.

2004 оны 9 дүгээр сарын 15-18-ны өдрүүдэд Япон Улсын Үндэсний Батлан хамгаалахын академийн ерөнхийлөгч ноён Нишихара тэргүүтэй төлөөлөгчид Батлан хамгаалахын сайдын урилгаар Монгол Улсад ажлын айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Батлан хамгаалах яам, болон Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагуудтай уулзаж харилцан сонирхож буй асуудлаар санал солилцсон. Ноён Нишихара айлчлалын явцад БХИС-д зочилж монголын цэргийн алба хаагчдыг цаашид Японы Үндэсний Батлан хамгаалахын академид үргэлжлүүлэн сургах тал дээр зарим нэг тохиролцоонд хүрсэн.

2006 оны 9 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд Монгол Улсын Батлан хамгаалах яамны урилгаар Япон Улсын Үндэсний батлан хамгаалах агентлагийн дарга, төрийн сайд ноён Ф.Нукага тэргүүтэй төлөөлөгчид албан ёсны айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Батлан Хамгаалахын сайд М.Сономпил ноён Ф.Нукагатай хоёр талын хамтын ажиллагааны талаар хэлэлцээ хийж, солонгосын хойгийн асуудлаар байр сууриа харилцан илэрхийлсэн.

2009 оны 7 дугаар сард Японы өөрийгөө хамгаалах хүчний Мэдээллийн хэлтсийн дарга, хурандаа Осава, Япон Улсаас Монгол Улсыг хавсран суугаа батлан хамгаалахын атташе нар Монгол Улсад айлчилж хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон.

2012 оны 1 дүгээр сард Японы Батлан хамгаалахын сайд Ичикава Ясуо Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Айлчлалын үеэр хоёр орны батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичигт Батлан хамгаалахын сайд Л.Болдын хамт гарын үсэг зурсан.

2012 оны 10 дугаар 15-19-ний өдрүүдэд Японы Батлан хамгаалах яамны Чадавхыг дээшлүүлэх албаны дарга Х.Вагури тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлал хийсэн. Айлчлалын үеэр яамны СБТГ-ын дарга, бригадын генерал Д.Баярсайхантай санал солилцлоо.

2012 оны 11 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд Японы Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Каназава тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ нарт бараалхан, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал Я.Чойжамцтай уулзалт хийсэн.

2013 оны 8 дугаар сарын 6-10-ны өдрүүдэд Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Нэгдсэн штабын дарга, генерал Ш.Ивасаки тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав нартай хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны асуудлаар уулзалт хэлэлцээ хийсэн.

2014 оны 6 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний Ерөнхий зориулалтын цэргийн командлагч, бригадын генерал Р.Сүхбатын урилгаар Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Хуурай замын цэргийн командлагч генерал К.Ивата тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Айлчлалын албан ёсны яриа хэлэлцээрийн үеэр талууд Цэргийн эмнэлгийн чиглэлээр шинэ эмнэлэг барьж байгаатай холбогдуулан тоног төхөөрөмж нийлүүлэх талаар судлах, Цэргийн инженерийн чиглэлээр замын инженерийн сургалтыг хөтөлбөрийн хүрээнд 2015, 2016 онуудад үргэлжлүүлэн зохион байгуулах, ЭДА-ны чиглэлд "Хааны эрэлд" хамтарсан хээрийн сургуульд ирэх жилүүдэд Япон Улсаас илүү өргөн бүрэлдэхүүнтэй оролцуулах, Терроризмтой тэмцэх тусгай хүчний хамтарсан сургуулийн талаар судлан үзэх, Цэргийн боловсон хүчний бэлтгэлд анхааран, цаашид нарийн мэргэжлээр сургах асуудлаар судалж үзэх, Гамшгаас хамгаалах, гамшигтай тэмцэх чиглэлд хамтран ажиллах боломжийг илэрхийлэх зэрэг асуудлаар хэлэлцэж тохирсон.

Япон Улсын Батлан хамгаалах яамны Батлан хамгаалах бодлогын газрын Олон улсын бодлогын хэлтсийн "Цэргийн салбарын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн албаны хуулийн мэргэжилтнүүдийн айлчлал, уулзалтыг 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

2015 оны 5 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Японы Өөрийгөө хамгаалах хүчний цэргийн инженерийн мэргэжилтнүүд Монгол Улсад ажлын айлчлал хийж, инженерийн цэргийн хамтын ажиллагаа, чадавхыг дээшлүүлэх хөтөлбөрийн асуудлаар тохиролцсон.

Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Т.Сайто тэргүүтэй тус хүрээлэнгийн 62 дахь удаагийн элсэлтийн оюутнуудын Монгол Улсад хийсэн айлчлалыг 2015 оны 6 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд хүлээн авсан.

Япон Улсын Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Ниши тэргүүтэй төлөөлөгчдийн "Цэргийн салбарын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд явагдсан сургалтын нээлтийн арга хэмжээнд оролцохоор Монгол Улсад хийсэн ажлын айлчлалыг 2015 оны 7 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Япон Улсын Батлан хамгаалах яамны Олон Улсын Бодлогын хэлтсийн "Цэргийн салбарын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн

албаны дарга К.Сато тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн салбарын “Цэргийн салбарын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулсан хамтарсан сургалт, дадлагын хаалтын ажиллагаанд оролцохоор Монгол Улсад хийсэн айлчлалыг 2015 оны 9 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Япон Улсын Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Мимура тэргүүтэй төлөөлөгчид 2015 оны 10 дугаар сард Монгол Улсад ажлын айлчлал хийж, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга хурандаа Б.Батсайхантай уулзалт хийсэн.

Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Тусгай хүчний төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн ажлын айлчлалыг 2016 оны 3 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Япон Улсын Батлан хамгаалахын парламентын дэд сайд Т.Кобаяши 2016 оны 9 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд “Цэргийн салбарын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчинтэй хамтарсан хоёр талын замын сургалт дадлагатай танилцсан.

“Хааны эрэлд” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлагад Япон Улсаас жил бүр сургагч багш, ажиглагч, салааны бүрэлдэхүүнтэйгээр идэвхтэй оролцож, 2017 онд Японы Өөрийгөө хамгаалах хүчний Хуурай замын цэргийн штабын орлогч дарга, дэслэгч генерал Г.Юаса айлчлал хийж, Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Б.Амгаланбаатартай санал солилцсон. Энэ жил хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй буюу 85 цэргийн алба хаагчтайгаар “Хааны эрэлд 2022” олон улсын сургалтад оролцсон.

2017 оны 12 дугаар сард Япон Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн ерөнхийлөгч Р.Кокубүн, дэд профессор Т.Киношита нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, БХЯ-ны СБТГ-ын дарга, бригадын генерал Г.Сайханбаяр, ҮБХИС-ийн захирал хошууч генерал Я.Чойжамц нартай албан ёсны уулзалт хийж, хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэгийн Аюулгүй байдлын зөвлөх К.Соноүра, 2018 оны 8 сард “Цэргийн салбарын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдаж буй Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчинтэй хамтарсан хоёр талын “Зам” сургалт дадлагын явцтай танилцах, хамтарсан сургалт дадлагын хаалтын арга хэмжээнд оролцсон.

Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Энхийг сахиулах ажиллагааны сургалтын төвийн дарга, хурандаа Х.Ёкояма 2022 оны 07 сард Монгол Улсын Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвтэй танилцаж, төвийн удирдлагатай энхийг сахиулах ажиллагааны сургалтын асуудлаар санал солилцсон.

Цэргийн сургалт, бэлтгэл, хамтарсан төсөл, хөтөлбөр:

Японы цэргийн академи, их, дээд сургуулиудад 1998 оноос хойш манай Зэвсэгт хүчнээс давхардсан тоогоор нийт 86 /12/⁴ цэргийн алба хаагч суралцсан болон суралцаж байна.

Батлан хамгаалах судалгааны хүрээлэнгийн дээд дамжаанд 1998 оноос 2 цэргийн алба хаагч, Хуурай замын цэргийн команд штабын коллежид 2009 оноос 11 /1/цэргийн алба хаагч, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн магистрын сургалтад 2000 оноос 15 /2/ цэргийн алба хаагч, бакалаврын сургалтад 53 /9/, Фүжигийн офицерын сургуулийн офицерын ахисан түвшний дамжаанд 2017 оноос 5 цэргийн алба хаагч тус тус суралцсан. Төгсөгчдөөс бригадын генерал цолтон 1 /бригадын генерал Б.Даваадорж/, хурандаа цолтон 6 төрсөн байна.

2012 оны 8 дугаар сараас 11 сарын хооронд Япон Улсын Үндэсний батлан хамгаалах академийн сонсогч Монгол Улсын Батлан хамгаалахын их сургуульд орос хэлний дамжаанд суралцаж төгссөн.

“Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургууль, дадлагад Японы Өөрийгөө хамгаалах хүчний бүрэлдэхүүн 2017 оноос тасралтгүй оролцож ирсэн. 2022 онд хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй буюу 85 цэргийн алба хаагчтайгаар “Хааны эрэлд 2022” олон улсын сургалтад оролцсон.

Япон Улсын БХЯ-наас бусад гадаад улс оронд хэрэгжүүлж буй “Цэргийн салбарын чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг 2014 оноос хэрэгжүүлж, “Зам” сургалтыг жил бүр зохион байгуулж инженерийн цэргийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Хүмүүнлэгийн тусламж, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалтын хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2015 онд УИХ-аар соёрхон батлуулсан.

Мөн 2021 онд Япон улсаас Монгол Улсын Батлан хамгаалах салбарт 20,119,550 төгрөгийн үнэ бүхий гал командын автомашин 3 нэгж, түргэн тусламжийн автомашин 2 нэгжийг тус тус буцалтгүй тусламжаар хүлээн авч Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад ашиглаж байна.

Олон улсын хурал, бусад арга хэмжээ:

Японы БХЯ-наас зохион байгуулдаг Батлан хамгаалах удирдах ажилтны зөвлөгөөнд 1995 оноос, Токиогийн Батлан хамгаалахын форумд 2003 оноос, Ази, Номхон далайн бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны

⁴ // Одоо суралцаж буй цэргийн алба хаагчийн тоо

хөтөлбөрт 2016 оноос, Олон улсын агаар сансрын үзэсгэлэнд 2016 оноос, Гамшгийн үеийн хүмүүнлэгийн авран туслах ажиллагааны семинарт 2016 оноос жил бүр БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, төлөөллүүд оролцож ирсэн.

Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах академиас гадаадын төгсөгчдийн уулзалтыг 2021 онд анх удаа зохион байгуулж Монгол Улсын Зэвсэгт хүчний 7 цэргийн алба хаагч оролцсон. Тус арга хэмжээнд оролцогчдыг Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ хүндэтгэн оройн зоог барьсан⁵.

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Монгол цэргийн музейд болон Токио дахь Монгол Улсын ЭСЯ-нд Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, солилцооны гэрэл зургийн тусгай үзэсгэлэнг дэлгэж олны хүртээл болгосон.

Дүгнэлт:

Монгол, Японы “Стратегийн түншлэл”-ийн харилцаа, хамтын ажиллагааг “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн шинэ шатанд хүргэн хамтын ажиллагааны хэтийн төлөв, зорилтыг тодорхойлж буй энэ цаг үед хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа зохих түвшинд амжилттай хөгжиж байна.

Бүс нутагт аюулгүй байдлыг хангах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, хуурай замын цэргийн хүрээнд цэргийн инженер, эмнэлэг, агаарын цэргийн хүрээнд нисэх хүчний болон радиолокацийн чиглэлээр болон тусгай хүчний чиглэлээр хамтран ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байна. Мөн энхийг сахиулах ажиллагаанд цэргийн алба хаагчдыг сурган дадлагажуулах, хамтран үүрэг гүйцэтгэх, цэргийн алба хаагчдыг шаталсан сургалтад хамруулах, мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр ч идэвхжүүлэн хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

⁵ https://www.kantei.go.jp/jp/98_abe/actions/201911/28reception.html